



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр
Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88
E-mail: info@inspection.gov.mn
http://www.inspection.gov.mn

“КЛАССИК ХАУС” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Л.БАТТӨР ТАНАА

2022.11.22 № 01-03-046/550

Барилга, байгууламжийн
ажлын зургийн тухай

“Классик хаус” ХХК-ийн эрүүл ахуйн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 22/108 дугаартай албан хүсэлтийн дагуу 480 суудалтай сургуулийн барилга байгууламжийн нэг маягийн ажлын зурагт “Эрүүл ахуйн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг үндэслэн эрүүл ахуйн хяналт хийлээ.

Хяналтаар барилгын захиалагчийн саналаар Мэргэжлийн хяналтын байгууллагаар загвар зураг хянуулснаас хойш ажлын зурагт өөрчлөлт оруулсан байна. Барилгын спорт зааланд агаар сэлгэлтийн систем төлөвлөөгүй зөрчлийг илрүүлж мэдэгдсэн.

“Классик хаус” ХХК-ийн зөрчил арилгаж дүгнэлт гаргуулах хүсэлтийн дагуу дахин хяналт хийсэн.

Нэг. Барилга байгууламжийн зориулалт:

Нэг маягийн 3 блок сургуулийн зориулалттай барилга.

Тус сургуулийн барилга нь ангиудын байрлах хэсэг тэнхлэгээрээ 24.0x53.2 метр харьцаатай зоорьтой 3 давхар, спорт заалны хэсэг нь тэнхлэгээрээ 18.0x32.1 метр харьцаатай зоорьтой 1 давхар, урлаг заалны хэсэг тэнхлэгээрээ 18.0x19.4 метр харьцаатай зоорьтой 2 давхар, Спорт заалны доор байрлах хөдөлмөрийн өрөөний таазыг дуу чимээ тусгаарлагч акустик хавтангаар өнгөлөхөөр, эдэлбэр газрын хэмжээ 2.88 га, барилгажилтын нийт талбай 2237.3м² хэмжээтэй цутгамал төмөр бетон каракастай, чулуун хөвөн дулаалгатай, ханын дүүргэлтийн хөнгөн блоктой, хуймал хавтгай дээвэртэй байхаар төлөвлөсөн.

Гадна аж ахуйн талбай, биеийн тамирын талбай, амралтын талбай, тоглоомын талбай, сургалтын талбай, хог цуглуулах талбай, туршилтын талбайтай байхаар;

Сургуулийн барилга зоорины давхартаа хонгил засварлах талбай, шатны хонгил, хувцасны өлгүүр, хөдөлмөрийн өрөө, багаж хэрэгслийн өрөө, агуулах, цахилгааны өрөө, дулааны өрөө, Гамшгаас хамгаалах хэрэгслийн агуулах, ариун цэврийн өрөө, ХБИ-ний ариун цэврийн өрөө, үйлчлэгчийн өрөө, ажилчдын амрах өрөө, хувцас солих өрөө, шүршүүрийн өрөө, хичээл давтах хэсэг, уншлагын танхим, мэдээллийн өрөө, компьютерын лаборатори, багшийн өрөө, туслах өрөө, сэтгэлзүйчийн өрөө, химийн лаборатори, олон зориулалттай өрөө байхаар;

1 дүгээр давхарт гонх, хонгил засварлах талбай, 5 бага анги, хувцас солих өрөө, шүршүүрийн өрөө, ариун цэврийн өрөө, ХБИ-ний ариун цэврийн өрөө, спорт заал, агуулах, тоног төхөөрөмжийн агуулах, багшийн өрөө, үйлчлэгчийн өрөө, эмчийн өрөө,

1522- 1155

тусгаарлах өрөө, архив, хоол үйлдвэрлэлийн газар, хооллох заал, жижүүрийн өрөө, уран зургийн өрөө байхаар;

2 дугаар давхарт хонгил засварлах талбай, 6 дунд анги, багш нарын өрөө, ариун цэврийн өрөө, ХБИ-ний ариун цэврийн өрөө, нийгмийн ажилтны өрөө, урлаг заал, хувцас солих өрөө, биологийн лаборатори байхаар;

3 дугаар давхарт хонгил засварлах талбай, 6 ахлах анги, эрхлэгчийн өрөө, ариун цэврийн өрөө, үйлчлэгчийн өрөө, санхүү, аж ахуйн өрөө, дуу хөгжмийн өрөө, техник хэрэгслийн өрөө, давхарт бүрд ХБИ-ний налуу зам байхаар тус тус төлөвлөсөн.

480 хүүхдийн барилгын халаалтын систем нь төвлөрсөн дулаан хангамжаас хангагдахаар, барилгын өрөө тасалгааны онцлогоос хамаарч агаарын орох болох соруулах механик системтэй байхаар, унд, ахуйн хэрэглээний усан хангамжийн эх үүсвэрийг холболт хийх байршлаас хамааруулан төвлөрсөн болон төвлөрсөн бус системээс хангах 2 хувилбараар төлөвлөсөн. Бохир усыг өөрийн урсгалаар нь барилгын 2 тийш гаралттай бохир усны худгаар дамжуулан төвлөрсөн бохир ус зайлуулах системд нийлүүлж зайлуулахаар тус тус төлөвлөжээ.

Хоёр. Дүгнэлт

“Классик хаус” ХХК-ийн боловсруулсан 480 хүүхдийн сургуулийн барилга байгууламжийн нэг маягийн ажлын зураг нь “Сургалт-хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох нэгдсэн норм” /БНБД II-66-88/, холбогдох стандартын шаардлага хангаж байна.

Дээрх 480 хүүхдийн сургуулийн барилга байгууламжийн ажлын зурагт гаргасан энэхүү эрүүл ахуйн дүгнэлт нь МХЕГ-ын ЭМХГ-ын даргын гарын үсэг зурж баталгаажсан нүүр хуудас болон улсын ахлах байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулсан хуудасны хамт хүчин төгөлдөр байна.

Энэхүү нэг маягийн зургийн дагуу баригдах 480 хүүхдийн сургуулийн барилгын халаалт, цэвэр бохир усны холболтын ажлын зургийг тухайн баригдах газрын нутаг дэвсгэр дэх Мэргэжлийн хяналтын байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчаар тухай бүр нь хянуулан дүгнэлт гаргуулсны дараа барилга байгууламжийг барьж байгуулахыг мэдэгдье.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  ЦОЛМОНБАЯР

ХҮЛЭЭН АВСАН:

КЛАССИК ХАУС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  Л.БАТТӨР